



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/492

Эрдэнэт


Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 4.1.25, 4.1.26, “Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын журам”-ын 3.1, 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрчим хүчний ажилтны өдөр, Эрүүл мэндийн ажилтны өдөр, Илгээлтийн эзэд-анхдагчдын өдөр, Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 40 жилийн ойг тус тус тохиолдуулан олон жил үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан хавсралтанд дурьдсан нэр бүхий иргэдийг Орхон аймгийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнаж урамшуулсугай.

2.Шагналд зарцуулагдах 3850000 /Гурван сая найман зуун тавин мянган/ төгрөгийг орон нутгийн бусад зардлын шагнал урамшууллын сангаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ